



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 22

Номгон

Эрчим хүчний хэмнэлтийн бодлого  
аймгийн хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний хэмнэлтийн бодлого 2019-2020 онд хэрэгжүүлэх аймгийн хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, шаардлагатай төсөв, зохион байгуулах ажлыг аймгийн жил бүрийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөвт тусгаж батлуулан, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

90  
Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын  
Тэргүүлэгчдийн 2019 оны 03 дугаар сарын 19-ний  
өдрийн 22 дугаар тогтоолын хавсралт

**ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТИЙН БОДЛОГО  
АЙМГИЙН ХӨТӨЛБӨР**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Баянхонгор аймагт 2018 оны байдлаар цахилгаан хэрэглэж буй айл өрхийн тоо 8596 буюу 70,9%, орон сууц 2504 буюу 20,6%, аж ахуйн нэгж 1012 буюу 8,3%-ийг тус тус эзэлж байна. Нийтдээ 12112 хэрэглэгч байна.

Баянхонгор аймгийн өрхийн тоо, халаалтын эх үүсвэрээр авч үзвэл нийт 9668 өрх байгаагаас төвлөрсөн системд 1682, нам даралтын зуухаар 123, цахилгаан халаагуураар 5, ердийн галлагаагаар 7858 өрх халаалтаа шийдвэрлэж байна. 2018 оны байдлаар Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо 837, Төсвийн байгууллага 186 байна. Энэхүү нийт байгууллага өрхүүд цахилгаан дулаан хэрэглэж байна.

Эрчим хүчийг үр ашигтай хэрэглэх нь улсын төсвийг хэмнэх, өрхийн хэрэглээний зардлыг бууруулах, байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлэх, зүй зохистой хэрэглээг төлөвшүүлэх, ард иргэдийн ая тухтай амьдрах орчныг сайжруулах давуу талыг бий болгодог.

Аймаг сумдын эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах төрийн нэгдсэн бодлогын хүрээнд эрчим хүчийг хэмнэх, түүний үр ашгийг нэмэгдүүлэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, нийтийн боловсролд чиглэсэн эрчим хүчний хэмнэлтийн талаарх мэдээлэл, сурталчилгааны нэгдсэн системийг бий болгох, барилга байгууламжийн зураг төсөлд эрчим хүчний хэмнэлттэй, ашиглалтын зардал багатай шийдлүүдийг тусгах, барилгын дулаан алдагдлыг бууруулах зэрэг шаардлагатай арга хэмжээнүүдийг цогцоор нь шийдвэрлэх шаардлагатай байна.

Баянхонгор аймагт дулаан үйлдвэрлэх, түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч 21 ХХК үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс Баянхонгор сумд 11 тусгай зөвшөөрөл эзэмшигч үйл ажиллагаа явуулдаг. Энэхүү үйл ажиллагаа явуулж буй компаниудад утааны шүүлтүүр, үнс баригч байхгүй байгаа нь хүлэмжийн хийн ялгарал их байгаатай шууд холбоотой байна.

Цахилгаан эрчим хүчийг хэмнэхэд аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн мэдлэг дутмаг байдаг. Албан газар, ААНБ, орон сууцанд оршин сууж буй иргэд

барилгын дулаан алдагдлыг тодорхойлох талаар ойлголтгүй байдаг.

Хоёр.Хөтөлбөрийн зорилго

2.1 Орон нутгийн шийдвэр гаргах түвшинд оролцоог нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэх, орлого нэмэгдүүлэх, төсөв зардлыг хэмнэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй нягт уялдуулан хэрэгжүүлнэ. Мөн хэрэглэгчдэд цахилгаан эрчим хүчийг хэмнэх, барилгын дулааныг тодорхойлох талаар зохих хэмжээний мэдлэгийг олгох юм.

Нийт 4 зорилгын хүрээнд зорилт дэвшүүлэн ажиллана.

- 2.1.1.Хэрэглэгчдэд цахилгаан эрчим хүч, дулааныг хэмнэх
- 2.1.2.Хэрэглэгчдэд барилгын дулаан алдагдалыг тодорхойлох
- 2.1.3.Хүлэмжийн хийг бууруулах, цахилгаан халаагуур хэрэглэх
- 2.1.4.Уурын зуухны янданд шүүлтүүр тавих
- 2.1.5.Эрчим хүчийг хэмнэх мэдээллийн нэгдсэн сантай болох

Гурав. Хөтөлбөрийн зорилтууд

3.1.Аймгийн хэмжээнд эрчим хүчний хэмнэлтийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг сайжруулна.

3.2.Эрчим хүч, цахилгаан хэмнэх талаар хэрэглэгчдэд сургалт зохион байгуулна.

3.3.Орон нутгийн мэдээллийн хэрэгсэл болон цахим хуудсаар дамжуулан цахилгаан, дулаан хэмнэх, барилгын дулааны алдагдлыг тодорхойлох талаар ойлголтыг өгнө.

3.4.Хүлэмжийн хийг бууруулах зорилгын хүрээнд гэр хороололд оршин суугч нийт иргэдийг 2 тарифт тоолуураар бүрэн хангах

3.5.Цахилгаан халаагуурыг иргэдэд таницуулан сурталчилж худалдан борлуулах үйл ажиллагааг зохион байгуулах

3.6.Баянхонгор сумд үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудад албан шаардлага хүргүүлэх, аймгийн удирлагууд тусгай зөвшөөрөл эзэмшигч компаний захиралуудтай хамтран уулзалт зохион байгуулна.

3.7.Тусгай зөвшөөрөл эзэмшигч компаний ажилчдад мэргэжил дээшлүүлэх цахилгаан дулаан хэмнэх тухай сургалт, семинар зохион байгуулах

3.8.Баянхонгор аймгийн ЕБС-ын нийгмийн ажилтнуудад эрчим хүч дулааныг хэмнэх талаарх сургалтыг Эрчим хүчний зохицуулах хорооны мэргэжилтнүүдтэй хамтран сургалт зохион байгуулах.

3.9.Эрчим хүчийг хэмнэх талаар хэрэглэгчдэд гарын авлага бэлдэн тодорхой цэгүүдэд самбар байршуулах

Дөрөв. Хүрэх дүн, шалгуур үзүүлэлт

4.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрсэн байна.

4.1.1.Хэрэглэгчид цахилгаан эрчим хүч дулааныг хэмнэх талаар ойлголттой болж төсвийн болон өрхийн хэрэглээний зардал тодорхой хэмжээгээр буурсан байна.

4.1.2.Хэрэглэгчид барилгын дулаан алдагдалыг бууруулснаар хэрэглэгчийн ажиллаж амьдрах ая тухтай орчин сайжирна.

4.1.3.Гэр хороололд 2 тарифт тоолуур тавьснаар цахилгаан халаагуур ашиглах боломжийг бүрдүүлж агаарын бохирдол тодорхой хэмжээнд буурна.

4.1.4.Уурын зуухны янданд шүүлтүүр тавьснаар хүлэмжийн хий буурч, яндангаас гарч буй хог хаягдал буурна.

4.1.5.Эрчим хүчний мэдээллийн нэгдсэн сантай болсон байна.

4.1.6.Хэрэглэгчийн оролцоо нэмэгдсэнээр агаарын бохирдлын хэмжээ буурч, цахилгаан болон дулаан эрчим хүчийг хэмнэх бүтээлч хандлага нэмэгдсэн байна.

4.1.7.Орон нутгийн онцлог хэрэгцээнд тулгуурлан эрчим хүчийг хэмнэх, агаарын бохирдлыг бууруулах 2-3 шилдэг санааг хүлээн авч дэмжин хамтран ажиллана.